



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

「МОНГОЛЫН ТАКСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ」
ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН
Ц.НАРМАНДАХ ТАНАА

2017. 02. 13 № 02-01/549
танай _____ -ны № _____ -т

「Мэдэгдэл хүргүүлэх тухай」

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 96 дугаартай тушаалаар баталсан "Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчдын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх заавар"-ын 3.6 дахь заалтыг үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийтийн таксийн тээврийн үйлчилгээний зохион байгуулалт, зохицуулалт, тээврийн хэрэгслийн техникийн болон тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар уг үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад дараах мэдэгдлийг хүргүүлж байна.

Монгол Улсын "Автотээврийн тухай", "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулиудын хэрэгжилт, холбогдох дүрэм, журам, улсын стандартад заасан шаардлагуудыг хангаж ажиллах үүднээс дор дурдсан арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Монгол Улсын "Автотээврийн тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2, 10.2.2¹, 10.2.6 дахь заалтад зааснаар зорчигчийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тав тухтай, аюул, осолгүй тээвэрлэх, тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх, автотээврийн хэрэгслийн хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаж ажиллах;

2. Мөн хуулийн 17.2 дахь заалтад заасны дагуу тээврийн хэрэгслүүдийг тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулж, үзлэгт тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд гаргахгүй байх;

3. Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолын дагуу хийж буй байгууллагынхаа дотоод хяналт шалгалтын ажлыг сайжруулах, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах, ажлын тайланг улирал

бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт ирүүлэх;

4. "Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм"-ийн 2.6 дахь заалт, "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS5122:2013 улсын стандартын 7.4, 7.7-д тус тус заасны дагуу үйлчилгээнд гарахын өмнө жолооч нарыг эрүүд мэндийн үзлэгт оруулж, таксийн тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцлийг хэрхэн хангасныг шалгаж, замын хуудсыг баталгаажуулж байх;

5. "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS5122:2013 улсын стандартын 5.4, 7.11-д тус тус заасны дагуу таксийн тээврийн хэрэгслүүдэд үйлчилгээг шуурхай зохион байгуулах, жолооч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор холбоо, мэдээллийн хэрэгсэл болон байрлал тогтоох, бүртгэл хяналтын төхөөрөмж суурилуулах, хэмжилзүйн байгууллагаар шалгуулж баталгаажуулсан таксометрээр тоноглож, зорчигчдын эрхийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

6. "Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо. Тодорхойлолт" MNS4601:2011 улсын стандартын 7-д зааснаар тээврийн хэрэгсэлд хийх техникийн үйлчилгээ, засварын ажлыг тогтоосон хуваарийн дагуу бүрэн гүйцэд хийж, техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах;

7. Таксийн тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн утааны найрлага дахь агаар бохирдуулах бодис /CO, CH/ -ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, автотээврийн хэрэгслийн ашиглалтаас агаар орчинд хаягдаж байгаа агаар бохирдуулах бодисын хэмжээг багасгах, улмаар агаарын бохирдол, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буй сөрөг нөлөөг бууруулж, арилгахад автотээврийн хэрэгслийн ашиглалт, техникийн байдалд тавих хяналтыг хүчтэй болгох;

8. Таксийн үйлчилгээг худалдаа, үйлчилгээний цэг, салбарууд төвлөрсөн, зорчигч урсгал, хүн амын бөөгнөрөл ихтэй газруудад байгуулагдсан таксийн зогсоолын тэмдэг, гэрэлтүүлэг бүхий байнгын болон түр зогсоолуудаас үзүүлэх шаардлагатай байна. Тус газарт Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт Энхтайвны гүүрний баруун доод талд байрлах "Петростар" ХХК-ний шатахуун түгээх станцын шатахуун буулгах, түгээх талбайд танай холбооны "Элит ноён такси" ХХК, "Тэрбо сервис" ХХК, "Улаанбаатар такси" ХХК, "Бүргэд такси" ХХК, "Гранд такси" ХХК-ниудын таксийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүд удаан хугацаагаар зогсох, засвар үйлчилгээ хийх, жолооч нар нь тамхи татах зэрэг зөрчлүүд гаргаж байгаа

талаар дээрх компаниас гомдол удаа дараа ирүүлсэн болно. Иймд зорчлийн талаар дээрх аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Энэхүү мэдэгдлийг нийтийн таксийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй бүх аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, зохион байгуулсан ажил, авсан арга хэмжээний талаар 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор манай байгууллагад хариу ирүүлнэ үү.

Тус газраас Замын цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Даваазулд хүргүүлсэн 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02-01/515 дугаартай албан бичгийг хувилж хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА



ЭРДЭНЭЧУЛУУН